



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.2.5, 6.4.3, 6.5, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэрийн, нийт 211,162.98 (хоёр зуун арван нэгэн мянга нэг зуун жаран хоёр доллар өрэн найман цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Энхцэцэг, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин Сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D.Naran

Д.НАРАНГЭРЭЛ

000555

Төрийн өмчийн борцлого,
зохицуулалтын газрын 2020 оны 05
дугаар сарын 20-ны өдрийн
21/дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, актаж, худалдах хөрөнгийн жагсаалт

| № | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ, Хууримтлагдсан эпэгдэл (ам.доллар) | Худалдах доод үнэ (ам.доллар) | Байршил |
|---|---|--------------------------------------|-----------------|--|----------------------------------|--------------|
| 1 | Лексус LS460 Маркийн PEY1106 дугаартай, Арлын дугаар -TRH214-0027105 | 2012/2012 | 72300 | 129,089.96 | 1,000.00 | Осака ЕКГ |
| 2 | Volsbagen caravella-2 маркийн, KPN281 дугаартай, суудлын автомашин арлын дугаар TDI DSG Sequential 9 14HP2010 | 2010/2015 | 181560 | 5,153.02 | 1,000.00 | Стокхолм ЭСЯ |
| 3 | Мерседенс E-350 маркийн, суудлын, арлын дугаар 384820 | 2010/2011 | 35500 | 48,000.00 | 1,000.00 | Кайр ЭСЯ |
| 4 | Бенз маркийн, Н0006 дугаартай, суудлын, арлын дугаар WDDNG9FBAAZ298328 | 2009/2012 | 236845 | 28,920.00 | 1,000.00 | Эрээн КГ |
| | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | | 211,162.98 (хоёр зуун арван нэгэн мянга нэг зуун жаран хоёр доллар ерэн найман цент) | 4,000.00 (дөрвөн мянга амдоллар) | |